

MONGOLIA



Treaty Series No. 53 (1973)

# Trade Agreement

between the  
United Kingdom of Great Britain and Northern Ireland  
and the Mongolian People's Republic

London, 21 March 1973

[The Agreement entered into force on 21 March 1973]

*Presented to Parliament  
by the Secretary of State for Foreign and Commonwealth Affairs  
by Command of Her Majesty  
May 1973*

LONDON

HER MAJESTY'S STATIONERY OFFICE

8p net

Cmd. 5306

**TRADE AGREEMENT  
BETWEEN THE UNITED KINGDOM OF GREAT BRITAIN AND  
NORTHERN IRELAND AND THE MONGOLIAN PEOPLE'S  
REPUBLIC**

The Government of the United Kingdom of Great Britain and Northern Ireland and the Government of the Mongolian People's Republic (hereinafter called "the Contracting Parties");

Wishing to strengthen and develop trade relations between their two countries on the basis of reciprocity and mutual advantage;

Have agreed as follows:

**ARTICLE 1**

(1) The Contracting Parties resolve to encourage an expansion of the import and export trade between their two countries during the period of validity of this Agreement.

(2) To this end the Contracting Parties shall, within the scope of the laws and regulations in force in their respective countries, facilitate the exchange of goods and services between the two countries on a mutually advantageous basis, subject to the essential security interests of each country.

**ARTICLE 2**

(1) The Contracting Parties shall grant to each other most-favoured-nation treatment in respect of customs duties, tariffs and other charges, as well as of regulations and formalities connected with the import and export of goods and services.

(2) The provisions of paragraph (1) of this Article shall not be construed as a hindrance to the advantages granted by either Contracting Party to any other country under the provisions of any agreement or arrangement concluded on mutually favourable conditions with another country or other countries and which constitute or lead to the establishment of a customs union, free trade or preference area.

**ARTICLE 3**

Payment for goods and services within the terms of this Agreement shall be effected in freely convertible currency, in accordance with the foreign exchange regulations in force in the respective territories of the Contracting Parties.

**ARTICLE 4**

Each Contracting Party shall facilitate in its own territory and within the laws and regulations there in force, the entry, stay, residence and commercial activities of the nationals of the other Party in order to develop trade between the two countries.

#### ARTICLE 5

Representatives of the Contracting Parties shall meet at any time when both Contracting Parties deem this necessary in order to study proposals for the improvement of commercial relations or any other matter relating to the implementation of this Agreement.

#### ARTICLE 6

Each Contracting Party reserves the right to open negotiations with the other Contracting Party in the light of its own international obligations. Such consultations however shall not call into question the basic objectives of this Agreement.

#### ARTICLE 7

The termination of this Agreement shall not affect the fulfilment of contracts concluded between institutions and enterprises in the two countries during the validity of this Agreement.

#### ARTICLE 8

The Contracting Parties shall use their best endeavours to encourage the organisation of and participation in trade fairs and exhibitions to be held in the territory of their two countries.

#### ARTICLE 9

In relation to the Government of the United Kingdom the territory to which this Agreement shall apply shall be Great Britain and Northern Ireland.

#### ARTICLE 10

This Agreement shall enter into force upon signature by both Contracting Parties and shall remain in force until 31 December 1974.

IN WITNESS WHEREOF the undersigned, duly authorised thereto by their respective Governments, have signed this Agreement.

DONE in duplicate at London this 21st day of March 1973, in the English and Mongolian languages, both texts being equally authoritative.

For the Government of the United Kingdom of Great Britain and Northern Ireland: For the Government of the Mongolian People's Republic:

ANTHONY ROYLE

LIMERICK

ДАМБАДАРЖАА

**ИХ БРИТАНИ БА УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН  
ВАНТ УЛС, БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД  
УЛСЫН ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР**

Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд" гэж нэрлэгдэх/ тэгш эрх, харилцан ашигтай байх үндсэн дээр тус хоёр орны хооронд худалдааны харилцааг бэхжүүлэн хөгжүүлэхийг хүсэж дор дурдсан зүйлүүдийн талаар тохиролцов.

**Нэгдүгээр зүйл**

1. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаанд тус хоёр орны хоорондын импорт, экспортын худалдааг өргөжүүлэхийг эрмэлзэнэ.

2. Энэхүү зорилгоор Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд орон тус бүрийн аюулгүй байдлын амин чухал эрх ашгийг эрхэмлэн сахиж тус тусын оронд мөрдөж байгаа хууль дүрмийн дагуу харилцан ашигтай байх үндсэн дээр хоёр орны хооронд харилцан бараа солилцох ба үйлчилгээ үзүүлэх явдлыг дэмжинэ.

**Хоёрдугаар зүйл**

1. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд гаалийн татвар, тариф болон бусад хураамж, түүнчилэн экспорт, импортын бараа, үйлчилгээтэй холбогдсон дүрэм, журмын талаар хамгийн тааламжтай нөхцөлийг бие биедээ үзүүлнэ.

2. Энэ зүйлийн I-ийн заалт нь нэг буюу олон оронтой харилцан тохиромжтой байх нөхцөлийн үндсэн дээр байгуулсан хэлэлцээр ба гаалийн холбоо, чөлөөт худалдааны болон хөнгөлөлттэй бүс байгуулах үндэс болох буюу түүнд хүргэх хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн Тохирогч аль нэг Этгээдээс бусад улсуудад үзүүлэх үлэмж давуутай нөхцөлд үл хамаарна.

## Гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд харилцан бараа нийлүүлэх ба үйлчилгээний төлбөрийг Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн нутаг дэвсгэр дээр хүчин төгөлдөр мөрдөж буй гадаад валютын дүрэм зааврын дагуу чөлөөт валютаар гүйцэтгэнэ.

## Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд хоёр орны хооронд худалдаа хөгжүүлэх зорилгоор өөрийн нутаг дэвсгэр дээр нөгөө этгээдийнхээ харьяат иргэдэд худалдааны үйл ажиллагаа явуулахаар орох, тэнд байх ба орон байр олоход тус бүрийн оронд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль дүрмийн дагуу дэмжлэг үзүүлж байх болно.

## Тавдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд шаардлагатай гэж үзвэл худалдааны харилцааг хөгжүүлэх, энэхүү Хэлэлцээрийг биелүүлэхтэй холбогдсон бусад ямар нэгэн асуудлын талаарх саналыг судлах зорилгоор, Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн төлөөлөгчид тухай бүрд уулзаж байна.

## Зургадугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн аль нэг нь олон улсын хэмжээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу нөгөө Хэлэлцэн Тохирогч Этгээдтэйгээ хэлэлцээ хийх эрх эдлэнэ. Гэвч ийнхүү зөвлөлдөн хэлэлцэх нь энэхүү Хэлэлцээрийн үндсэн зорилгод үл харшлана.

## Долдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хугацаа дуусах нь уг Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх үед тус хоёр орны үйлдвэр, байгууллагуудын хооронд байгуулсан контрактын үүргийг биелүүлэхэд нөлөөлөхгүй.

## Наймдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд тус хоёр орны нутаг дэвсгэр дээр худалдааны яармаг ба үзэсгэлэнг зохион байгуулж гаргах, тэдгээрт оролцохыг дэмжиж бүхий л бололцоогоор хангахыг эрмэлзэнэ.

## Есдүгээр зүйл

Нэгдсэн Вант Улсын Засгийн газар энэхүү Хэлэлцээрийг Их Британи ба Умард Ирландын нутаг дэвсгэр дээр хэрэглэн мөрдөнө.

## Аравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд гарын үсэг зурсан өдрөөс эхлэж хүчин төгөлдөр болох ба 1974 оны 12-р сарын 31 хүртэл хүчинтэй байна.

Дээр дурдсаныг нотлож тус тусын Засгийн газраас зохих ёсоор эрх олгосноор энэхүү Хэлэлцээрт дор нэр дурдсан хүмүүс гарын үсэг зурав.

1973 оны 3-р сарын 21-ний өдөр Лондон хотноо англи, монгол хэл дээр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёр эх хувь нь адил хүчинтэй байна.

ИХ БРИТАНИ БА УМАРД ИРЛАН-  
ДЫН НЭГДСЭН ВАНТ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ ОЛГОС-  
НООР

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ  
АРД УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ЭРХ ОЛГОСНООР

ANTHONY ROYLE

ДАМБАДАРЖАА

LIMERICK

**HER MAJESTY'S STATIONERY OFFICE**

*Government Bookshops*

49 High Holborn, London WC1V 6HB  
13a Castle Street, Edinburgh EH2 3AR  
109 St Mary Street, Cardiff CF1 1JW  
Brazennose Street, Manchester M60 8AS  
50 Fairfax Street, Bristol BS1 3DE  
258 Broad Street, Birmingham B1 2HE  
80 Chichester Street, Belfast BT1 4JY

*Government publications are also available  
through booksellers*